

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/117/НА-СТА-ТШЗ

Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Н.Туяа
Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.24 № 251
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГА Б.АМГАЛАНБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь тайлант онд орон нутгийн төсвөөс 2,330,039.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр 177,291.0 мянган төгрөгийн, өөрийн орлогоос 10,800.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр 2,316,788.5 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 190,025.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, ахмадын сангийн харилцах дансанд 8,916.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 4,161.7 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайланд 1,800.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тусгуулж, 2,361.7 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоож хүргүүлсэн.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 81 арга хэмжээ тусгаж, 93 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	145,286,324.59	307,286,556.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	8,916,500.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	8,916,500.00
3121	Төгрөг	00.00	8,916,500.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	8,916,500.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	00.00
33	АВЛАГА	40,208,912.00	58,561,100.00
335	Бусад авлага	40,208,912.00	58,561,100.00
3351	Байгууллагаас авах авлага	40,208,912.00	58,561,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	105,077,412.59	239,808,956.04
351	Түүхий эд материал	350,000.00	350,000.00
35110	Тусгай зориулалттай материал	350,000.00	350,000.00
354	Хангамжийн материал	104,727,412.59	239,458,956.04
35410	Бичиг хэргийн материал	1,996,300.00	133,859,500.00
35420	Аж ахуйн материал	101,091,112.59	102,555,966.00
35440	Түлш, шатах тослох материал	1,640,000.00	3,043,490.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	455,588,227.45	464,433,751.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	455,588,227.45	464,433,751.19
392	Биет хөрөнгө	406,159,177.33	420,563,451.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	61,853,245.00	48,177,863.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	-32,458,196.85	-17,458,196.85
39203	Авто-тээврийн хэрэгсэл	352,220,829.83	330,270,073.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-123,286,096.08	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	251,816,663.62	247,768,648.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-164,759,874.21	-94,340,617.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,876,321.88	65,481,720.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,805,323.66	-40,331,370.68
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	16,951,608.00	16,951,608.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,500,000.00	13,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,750,000.20	-6,650,000.28
393	Биет бус хөрөнгө	49,429,050.12	43,870,300.16
39301	Програм хангамж	35,550,000.00	34,850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-13,778,749.88	-17,427,499.84
39303	Бусад биет бус хөрөнгө	28,042,800.00	26,447,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-385,000.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	600,874,552.04	771,720,307.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	49,501,800.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	49,501,800.00
413	Өглөг	00.00	49,501,800.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	2,880,000.00
4136	Бусад өглөг	00.00	46,621,800.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	46,621,800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	600,874,552.04	722,218,507.23

51	Засгийн газрын хувь оролцоо	600,874,552.04	722,218,507.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	143,683,565.03	143,683,565.03
51101	Өмч: - төрийн	143,683,565.03	143,683,565.03
512	Хуримтлагдсан үр дүн	457,190,987.01	578,534,942.20
51210	Өмнөх үеийн үр дүн	457,190,987.01	457,190,987.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	121,343,955.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>600,874,552.04</u>	<u>771,720,307.23</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,355,890,300.00	2,614,969,561.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	148,616,000.00	147,848,261.62
120	Нийтлэг татварын бус орлого	148,616,000.00	147,848,261.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	148,616,000.00	147,848,261.62
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,600,000.00	12,600,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	147,016,000.00	135,248,261.62
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,207,274,300.00	2,467,121,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	160,306,500.00	137,082,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	90,687,000.00	29,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	69,619,500.00	108,082,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,046,967,800.00	2,330,039,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,046,967,800.00	2,330,039,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,303,497,116.55	2,492,415,606.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,303,497,116.55	2,492,415,606.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,060,394,520.18	2,316,759,443.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,104,392,250.15	1,404,119,236.41
210101	Үндсэн цалин	608,674,569.75	732,811,644.05
210102	Нэмэгдэл	377,725,572.40	488,791,152.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	87,280,000.00	140,355,000.00
210104	Урамшуулал	30,712,108.00	42,161,440.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,153,311.48	175,333,303.64
210201	Тэтгэврийн даатгал	93,978,941.31	119,226,646.28
210202	Тэтгэмжийн даатгал	11,049,202.46	14,026,664.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,519,761.35	7,013,332.31
210204	Ажилгүйдлийн даатгал	5,517,561.35	7,013,332.31
210205	Эрүүл мэндийн даатгал	22,087,845.01	28,053,328.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,770,188.00	51,002,582.30
210301	Гэрэл, цахилгаан	5,020,200.00	6,654,294.30
210302	Түлш, халаалт	32,547,088.00	33,707,038.00
210303	Цэвэр, бохир ус	7,202,900.00	10,641,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	72,252,036.55	74,812,404.55
210401	Бичиг хэрэг	5,427,600.00	11,801,000.00
210402	Тээвэр, шатахуун	40,638,878.00	25,656,509.96

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,452,140.00	1,983,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,188,850.00	2,362,100.00
210408	Бараа материал акталсны зардал	14,544,568.55	33,009,494.59
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,591,300.00	46,434,440.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,062,000.00	00.00
210604	Урсгал засвар	60,529,300.00	46,434,440.00
2107	Томилолт, зочны зардал	37,028,000.00	45,660,000.00
210702	Дотоод албан томилолт	37,028,000.00	45,660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	366,012,034.00	374,290,827.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	356,269,280.00	367,780,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,346,295.00	5,928,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	421,459.00	505,277.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,887,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	234,195,400.00	145,106,649.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	122,446,900.00	37,996,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,912,400.00	14,708,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,836,100.00	92,401,849.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	243,102,596.37	175,656,162.65
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	64,920,710.37	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	178,181,886.00	44,191,999.98
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	19,255,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,420,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	134,281,786.00	22,436,999.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,479,300.00	2,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	131,464,162.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	128,155,530.67
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,308,632.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	52,393,183.45	122,553,955.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,210,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,210,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,210,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	52,393,183.45	121,343,955.19

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,251,668,800.00	2,519,930,212.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,600,000.00	12,600,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,600,000.00	12,600,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,600,000.00	12,600,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,600,000.00	12,600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,250,068,800.00	2,507,330,212.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	203,101,000.00	177,291,012.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	133,481,500.00	69,208,912.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	69,619,500.00	108,082,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,046,967,800.00	2,330,039,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,046,967,800.00	2,330,039,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,209,429,800.00	2,506,813,812.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,209,429,800.00	2,506,813,812.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,926,118,291.63	2,272,596,549.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,104,392,250.15	1,404,119,236.41
210101	Үндсэн цалин	607,541,890.03	733,376,358.89
210102	Нэмэгдэл	378,523,845.22	488,803,834.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	87,614,406.90	140,016,675.61
210104	Урамшуулал	30,712,108.00	41,922,367.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,153,311.48	175,333,303.64
210201	Тэтгэврийн даатгал	93,978,941.32	119,226,646.28
210202	Тэтгэмжийн даатгал	11,049,202.45	14,026,664.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,519,761.35	7,013,332.31
210204	Ажилгүйдлийн даатгал	5,517,561.35	7,013,332.31
210205	Эрүүл мэндийн даатгал	22,087,845.01	28,053,328.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,770,188.00	51,002,582.30
210301	Гэрэл, цахилгаан	5,020,200.00	6,654,294.30
210302	Түлш, халаалт	32,547,088.00	33,707,038.00
210303	Цэвэр, бохир ус	7,202,900.00	10,641,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,834,808.00	39,873,800.00
210401	Бичиг хэрэг	6,303,100.00	8,622,200.00
210402	Тээвэр, шатахуун	37,088,878.00	27,060,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,452,140.00	1,671,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,990,690.00	2,520,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,395,500.00	44,992,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,496,600.00	3,875,000.00
210604	Урсгал засвар	31,898,900.00	41,117,000.00
2107	Томилолт, зочны зардал	36,218,000.00	42,780,000.00
210702	Дотоод албан томилолт	36,218,000.00	42,780,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	373,642,034.00	456,990,827.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	363,899,280.00	450,480,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,346,295.00	5,947,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	421,459.00	485,977.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,887,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	138,712,200.00	57,504,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	122,784,400.00	42,796,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,927,800.00	14,708,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	283,311,508.37	234,217,262.65
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	105,129,622.37	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	178,181,886.00	44,191,999.98
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	19,255,000.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,420,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	134,281,786.00	22,436,999.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,479,300.00	2,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	190,025,262.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	128,155,530.67
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	61,869,732.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	42,239,000.00	13,116,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	44,835,700.00	4,199,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	44,835,700.00	4,199,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	44,835,700.00	4,199,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	44,835,700.00	4,199,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-44,835,700.00	-4,199,900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-2,596,700.00	8,916,500.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,596,700.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	8,916,500.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	143,683,565.03	00.00	404,797,803.56	548,481,368.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	143,683,565.03	00.00	404,797,803.56	548,481,368.59
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	197,510,215.35	197,510,215.35
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	143,683,565.03	00.00	457,190,987.01	600,874,552.04
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	143,683,565.03	00.00	457,190,987.01	600,874,552.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	143,683,565.03	00.00	457,190,987.01	600,874,552.04
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	121,343,955.19	121,343,955.19
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	143,683,565.03	00.00	578,534,942.20	722,218,507.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,330,039,200.00	2,201,883,669.33	128,155,530.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,330,039,200.00	2,201,883,669.33	128,155,530.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,285,227,200.00	2,160,191,669.35	125,035,530.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,436,829,100.00	1,404,119,236.41	32,709,863.59
210101	Үндсэн цалин	746,946,000.00	733,376,358.89	13,569,641.11
210102	Нэмэгдэл	507,522,100.00	488,803,834.21	18,718,265.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	140,180,000.00	140,016,675.61	163,324.39
210104	Урамшуулал	42,181,000.00	41,922,367.70	258,632.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,359,900.00	175,333,303.64	5,026,596.36
210201	Тэтгэврийн даатгал	122,644,700.00	119,226,646.28	3,418,053.72
210202	Тэтгэмжийн даатгал	14,428,800.00	14,026,664.25	402,135.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,214,400.00	7,013,332.31	201,067.69
210204	Ажилгүйдлийн даатгал	7,214,400.00	7,013,332.31	201,067.69
210205	Эрүүл мэндийн даатгал	28,857,600.00	28,053,328.49	804,271.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,955,100.00	47,336,302.30	9,618,797.70
210301	Гэрэл, цахилгаан	7,020,200.00	6,654,294.30	365,905.70
210302	Түлш, халаалт	38,732,000.00	30,040,758.00	8,691,242.00
210303	Цэвэр, бохир ус	11,202,900.00	10,641,250.00	561,650.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,855,600.00	26,873,800.00	5,981,800.00
210401	Бичиг хэрэг	5,480,800.00	4,562,200.00	918,600.00
210402	Тээвэр, шатахуун	19,540,000.00	18,120,000.00	1,420,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,672,500.00	1,671,350.00	1,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,162,300.00	2,520,250.00	3,642,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,630,800.00	21,338,400.00	10,292,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,078,200.00	1,404,900.00	1,673,300.00
210602	Тавилга	6,374,700.00	3,300,000.00	3,074,700.00
210604	Урсгал засвар	22,177,900.00	16,633,500.00	5,544,400.00
2107	Томилолт, зочны зардал	31,515,700.00	20,460,000.00	11,055,700.00

210702	Дотоод албан томилолт	31,515,700.00	20,460,000.00	11,055,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	495,471,000.00	448,510,827.00	46,960,173.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	487,700,000.00	442,000,000.00	45,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,200,000.00	5,947,850.00	252,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	486,000.00	485,977.00	23.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	77,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	887,000.00	00.00	887,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,610,000.00	16,219,800.00	3,390,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,600,000.00	12,600,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,010,000.00	3,619,800.00	3,390,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,812,000.00	41,691,999.98	3,120,000.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,812,000.00	41,691,999.98	3,120,000.02
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	22,375,000.00	19,255,000.00	3,120,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,437,000.00	22,436,999.98	0.02
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,330,039,200.00	2,201,883,669.33	128,155,530.67
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,330,039,200.00	2,201,883,669.33	128,155,530.67
132001	Орон нутгийн төсвөөс	2,330,039,200.00	2,201,883,669.33	128,155,530.67
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	60	46	14
620001	Удирдах ажилтан	4	4	0
620002	Гүйцэтгэх ажилтан	50	36	14
620003	Үйлчлэх ажилтан	6	6	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	177,291,012.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	177,291,012.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,421,280.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,666,280.00
210302	Түлш, халаалт	3,666,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,816,500.00
210401	Бичиг хэрэг	2,876,500.00
210402	Тээвэр, шатахуун	8,940,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,853,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,370,000.00
210604	Урсгал засвар	24,483,500.00
2107	Томилолт, зочны зардал	22,320,000.00
210702	Дотоод албан томилолт	22,320,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,480,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,480,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,285,000.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,196,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,089,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,869,732.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,869,732.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	61,869,732.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	177,291,012.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	177,291,012.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,208,912.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	110,082,100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 1,800.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайланд ахмадын сангийн харилцах дансны үлдэгдлийг 1,800,000.00 төгрөгөөр дутуу илэрхийлсэн алдаа нь УСНББОУС 1 - Толилуулга, санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байдал”, “Толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 2,361.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож хүргүүлэв.

3.1 Төлбөрийн акт

Тайлант онд 2 ажилтанд цалин, ээлжийн амралтын хоногийг давхардуулан тооцож 2,361,742.00 төгрөгийн цалинг илүү олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2-д Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэснийг мөрдөн ажиллаагүй тул төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

Байхгүй.

3.3 Зөвлөмж

Байхгүй.

Нийт илрүүлсэн 2,361.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Харилцах дансны үлдэгдлийг дутуу тусгасан	1	1,800.0	1	1,800.0			1	1,800.0				
Дүн	1	1,800.0	1	1,800.0	0	0	1	1,800.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалинг илүү тооцож олгосон	1	2,361.7	1	2,361.7								
Дүн	1	2,361.7	1	2,361.7								

5. Аудитын тайлангийн хавсралт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 42 - А237 0447 Чингис хот
ХЭА - 2026/117/НА-СТА - ТУА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 2 ажилтанд цалин, ээлжийн амралтын хоногийг давхардуулан тооцож 2,361,742.00 /Хоёр сая гурван зуун жаран нэгэн мянга долоон зуун дөчин хоёр/ төгрөгийн цалинг илүү олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2-д Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдалж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэснийг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү тооцож олгосон 2,361,742.00 /Хоёр сая гурван зуун жаран нэгэн мянга долоон зуун дөчин хоёр/ төгрөгийг Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дарга Б.Амгаланбатад хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ТУЯА